



**БУЛГАН АЙМГИЙН
ТЭШИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/137

Тэшиг сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 29 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Ой хээрийн түймрийн үед ажиллах тоноглогдсон туулах чадвар сайтай авто машин худалдан авах” БУТЭСЗДТГ/202301005 дугаартай ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн зөвлөмжийн дагуу “Гэрэлт Оньс” ХХК-д 56,000,000 (Тавин зургаан сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг олгосугай.

2.Дээрх аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батсайхан)-д үүрэг болгосугай

3.Гэрээнд заасан “Ой хээрийн түймрийн үед ажиллах тоноглогдсон туулах чадвар сайтай авто машин худалдан авах” ажлыг чанартай сайн гүйцэтгэхийг “Гэрэлт Оньс” ХХК - д даалгасугай.

4.Гэрээт ажлын санхүүжилтийг хууль журмын дагуу санхүүжүүлэхийг Санхүүгийн албаны дарга (Б.Бадамрэгзэд)-д зөвшөөрсүгэй.



Ж.ГАНСҮХ